

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БЕГ болон налайх политехник коллежоос Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын багш, удирдлага, эрдэмтэн, судлаачдын дунд зохион байгуулсан “ИРЭЭДҮЙД ХӨТЛӨХ ТҮНШЛЭЛ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал 2 үе шаттай хэлэлцүүлэгдлээ



Хувцасны загвар, оёдлын мэргэжлийн суралцагчид дизайны чиглэлээр сургалт явуулдаг Их дээд сургуулийн дунд зохион байгуулагддаг Хаврын гоёл- дизайн сургалт 2024 наадмын ГРАНПРИ шагналын эзэд боллоо



ШУТИС дээр зохион байгуулагдсан Их дээд сургуулиудын Цахилгаан хангамжийн олимпиадад цахилгааны багш Г.Цогбадрах 3-р байр эзэллээ



ОХУ-ЫН ЭРХҮҮ ХОТЫН КОЛЛЕЖ, ТЕХНИКУМЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ЗОЧИЛОО.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Эрхүү хотын “Эдийн засаг, аялал жуулчлал, ахуй үйлчилгээний коллеж”-ийн захирал Кудинова Н.Ф., “Хоолны үйлдвэрлэлийн техникум”-ийн захирал Бажина О.А., “Нисэх үйлдвэрлэл материал боловсруулалтын техникум”-ийн захирал Зяблева В.В. болон “Ангарын үйлдвэрлэлийн техникум”-ийн захирал Кудрявцева С.Г., нарын зочид төлөөлөгчид сургуулийн удирдлагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх багш, оюутан, суралцагчийн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцож, сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аялал жуулчлалын соёлын бүтээгдэхүүнтэй танилцах Монгол гэрийн өв соёл, монгол ёс заншилыг дээдлэх бахархах суралцагчдыг төлөвшүүлэх, мэргэжилдээ хандах хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Монгол гэр" аялал хичээлийг зохион байгууллаа

ЗБЖБҮА мэргэжлийн 1.2 -р курсын нийт 46 суралцагчид "Монгол гэр үзэсгэлэн"-тэй танилцах аялал хичээлд хамрагдлаа



БНСУ-ын КОЖИ ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ЗОЧИЛОО

Зочид төлөөлөгчид сургуулийн удирдлагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх 1+1 хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр санал солилцож, гагнуурчин мэргэжлийн ангийн оюутан, багш нартай уулзаж, кожи их сургуулийн талаар мэдээлэл өглөө



БНЭУ-аас МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХЭТ ЭЛЧИН САЙД ЗОЧИЛОО

БНЭУ-ын элчин сайд Атул Малхари Готсурвэ УУПК-д зочилж, сургуулийн удирдлагатай уулзан оюутан суралцагч, багш, ажилтнуудыг БНЭУ-ын Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, соёл, урлаг боловсролын түншлэлийн олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудлаар санал солилцон ярилцлаа



Бүгд найрамдах Чех улсад туршлага судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг амжилттай эхлүүлээ



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь НЭЭЛТТЭЙ, НОГООН, ЦАХИМ сургууль болох зорилгынхоо хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд сурч мэдсэн, бүтээсэнээ тайлагнах багш, суралцагчдын "МИНИЙ БҮТЭЭЛ - НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ" зохион байгуулагдаж байна



Үсчин гоо заслын суралцагчид БНСУ-н олон улсын "International beauty art competition" тэмцээнд амжилттай оролцлоо



Тус тэмцээнээс гоо заслын мэргэжлээр, Гранпри 3, алтан медаль, 4 мөнгөн медаль 7, хүрэл 2 авсан бол үсчин мэргэжлээр Гранпри 6, алтан медаль 3, мөнгөн медаль 2, хүрэл 2 авч амжилттай оролцлоо

